



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 12 сарын 06 өдөр

Дугаар А/624

Хэрлэн сум

Урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээг
зохион байгуулахад хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 3 дугаар сарын 03-ны 10 тоот тогтоолын 6 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.1.1 дэх зорилтын хүрээнд Галшар, Баянхутаг, Бэрх, Батноров, Баян-Овоо, Мөрөн, Өмнөдэлгэр, Цэнхэрмандал, Дэлгэрхаан, Жаргалтхаан, Өлзийт, Гурванбаян, Тахилгат сум, тосгонд нарийн мэргэжлийн эмч нарын үзлэг, шинжилгээг зохион байгуулахад 17,057,600 (арван долоон сая тавин долоон мянга зургаан зуун) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Үйл ажиллагааг өндөр түвшинд зохион байгуулж, удирдлага, арга зүйгээр хангаж ажиллахыг Эрүүл мэндийн газрын дарга (Л.Мэндбаяр)-д, зорилтот насны хүн амыг бүрэн хамруулж ажиллахыг сумын Засаг дарга, тосгоны Захирагч нарт тус тус үүрэг болгосугай.

3. Үзлэг, шинжилгээнд зарцуулагдах зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

4. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн зардлаас олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Нямдаваа)-т, арга хэмжээнд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (Д.Өнөрцэцэг)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

Аймгийн Засаг даргын 2022
оны 12 дүгээр сарын 06-ны
дугаар захирамжийн хавсралт

ҮЗЛЭГ, ШИНЖИЛГЭЭНИЙ ЗАРДЛЫН ТООЦОО

Д/д	Зардлын нэр	Нэг бүрийн үнэ	Тоо ширхэг	Бүгд үнэ
1	Томилолт	49,030	15 хоног, 16 хүн	5,883,600
2	Шатахууны зардал	Дизель 4200 л, 100 км-т 20 л	1140 км	966,000
3	Тэмбүүгийн тест	2400	500 ш	1,200,000
4	ДОХ-ын оношлуур	400 хүн тун	2,400 ш	960,000
5	С вирус	25000	900 ш	2,250,000
6	В вирус	25000	900 ш	2,250,000
7	Чихрийн шижингийн тест	50 хүн тун, 36000	900 ш	648,000
8	Хеликобактерийн тест	2000	1000 ш	2,000,000
9	Бээлий	900	1000 хос	900,000
10	Нийт дүн			17,057,600